



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2018.05.09 № 3/2821
танай _____-ны № _____-т

1442

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
АНГИ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,
ЗАХИРАГЧ НАР ТАНАА

Хөтөлбөр, удирдамж, үүрэг
хүргүүлэх тухай

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/120 дугаар тушаал, мөн даргын баталсан “Байгууллагын соёлыг дээшлүүлье” аяны удирдамжийг тус тус хүргүүлэв.

Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аян зохион байгуулах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргаас дараах үүргийг өгсөн. Үүнд:

1. Хөтөлбөрийг бие бүрэлдэхүүнд судлуулах, алба хаагч, иргэд, олон нийтэд сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, бүх шатны удирдах албан тушаалтнууд биечлэн хяналт тавьж ажиллах.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аян зохион байгуулах алба хаагч, ажлын хэсгийг тусгайлан гаргаж, аяны хүрээнд хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлж, явц, үр дүнг сар бүр тооцож ажиллах.

3. Анги, байгууллага бүр аяны нээлтийн арга хэмжээг энэ оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулах.

4. Аяны хүрээнд идэвх, санаачилгатай ажилласан албан тушаалтан, алба хаагч, хамт олон /хэлтэс, тасаг, хэсэг/-ыг шагнаж, урамшуулах.


5. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүжилтийн асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж байх.

6. Аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний явц байдлын талаарх тайлан, танилцуулгыг шаардлагын түвшинд материалжуулан, тогтоосон хугацаанд Аюулгүй байдлын хэлтэст ирүүлэх.

Үүргийн хэрэгжилтийг хангаж, ажиллана уу.

Хавсралт 2! хуудастай.

ДЭД ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



З.ДАШДАВАА

0903381



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, Дотоодын цэргийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр"-ийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөрийг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжүүлэх, алба хаагчдад зөв хандлага, дадал хэвшүүлэх чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажлыг уялдуулан явуулж байхыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллахыг Дэд дарга /цагдаагийн хурандаа З.Дашдаваа/-д, биелэлт, үр дүнг тооцож ажиллахыг Аюулгүй байдлын хэлтэс /цагдаагийн хурандаа Х.Буянтүмэн/, Хүний нөөц, сургалтын хэлтэс /цагдаагийн хурандаа Ж.Баясгалан/-ийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусгуулах, тусламж, төсөл, хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулахыг Санхүү, аж ахуйн албаны дарга /цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд/-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Захиргааны удирдлагын газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Бат-Өлзий/-д даалгасугай.

ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧ, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

С.БААТАРЖАВ

ХУУЛБАР ҮНЭН
Захиргааны удирдлагын газрын дарга,
цагдаагийн хурандаа

Б.Бат-Өлзий



УХГ0026

0901805

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
дотоодын цэргийн командлагчийн
2018 оны 04 дугаар сарын 07-ны
өдрийн 112 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

УХГ0025

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, өнөөгийн байдал

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь үүсч байгуулагдсан цагаасаа хойш нийгмийн хөгжлийн бүхий л үе шатуудад төр, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүрэг, хүсэлт шаардлагад нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, соёлын түвшингээ дээшлүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж, өөрийн гэсэн түүхэн уламжлал, туршлага, соёл, үнэт зүйлтэй, дагаж мөрдөх эрх зүйн орчинтой болсон хэдий ч байгууллага бүрийн тогтсон соёл, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын арга барил, алба хаагчдын зан суртахууны төлөвшил зэргээс шалтгаалан харилцан адилгүй түвшинд байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, харилцааны соёлын түвшинг тодорхойлох зорилгоор Цагдаагийн ерөнхий газраас 2018 оны 04 дүгээр сард иргэд, алба хаагчдын дунд судалгаа хийлгэж, дүгнэлт гаргасан. Үүнд:

➤ Дээрх ажлын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын дунд “Байгууллагын соёлын үнэлгээний санал асуулга”-аар явуулсан судалгаанд Улаанбаатар цагдаагийн хүрээний 52, орон нутгийн 28, нийт 80 анги, байгууллагын 4336 алба хаагч буюу нийт бүрэлдэхүүний 44.7 хувь хамрагдсаны 2143 буюу 49.0 хувь нь офицер, 2175 буюу 49.7 хувь нь ахлагч бүрэлдэхүүн байсан.

Насны хувьд 19-25 насны 14.9, 26-31 насны 37.6, 32-41 насны 35.7, 42 ба түүнээс дээш насны 11.8 хувийг эзэлж байгаа бол ажилласан жилийн хувьд 28.1 хувь нь 5, 25.6 хувь нь 10, 15.7 хувь нь 20 хүртэлх, 7.2 хувь нь 21-ээс дээш жил ажиллаж байгаа алба хаагчид оролцсон.

Байгууллагын соёлын түвшинг 13 бүлэг, 64 асуулгаар, 1.0-5.0 хүртэл оноогоор үнэлэхэд,

а/ алба хаагчийн санал санаачилга, бие даасан байдал, эрх чөлөөг хангах байдал “4.0 оноо буюу сайн”;

б/ удирдлагын арга барил, дэмжлэг “3.9 буюу дундаж”;

в/ харилцаа, хандлага “3.9 буюу дундаж”;

г/ хяналтын систем “3.8 буюу дундаж”;

д/ нэгдмэл байдал “3.8 буюу дундаж”;

е/ чин эрмэлзэл, үнэнч байдал “3.8 буюу дундаж”;

ж/ байгууллагын үйл ажиллагаа “3.8 буюу дундаж”;

з/ сургалт, ур чадварын хөгжил “3.8 буюу дундаж”;

и/ алба хаагчийн сэтгэл ханамжийн байдал “3.8 буюу дундаж”;

к/ эрсдлийг хүлээж авах сонирхол, хандлага “3.6 буюу дундаж”;

л/ нийгмийн дэмжлэг туслалцаа “3.5 буюу дундаж”;

м/ шагнал, урамшуулал, хангамж “3.4 буюу дундаж”;

н/ зөрчилдөөний хэм хэмжээ “3.2 буюу дундаж”, нийт үнэлгээ 3.7 оноо буюу дундаж түвшин”-д тус тус үнэлэгджээ.

➤ Сахилга, ёс зүйн зөрчил гаргаж, ёс зүйн төлбөртэй сургалтад хамрагдсан 497 алба хаагчид сэтгэл зүйн шинжилгээ хийсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 94.1 хувь нь эрэгтэй, 5.9 хувь нь эмэгтэй, дундаж наслалт 32.7, дунджаар 10.3 жил байна.

Шинжилгээгээр оролцогчдын 74.5 хувь нь ажлын хариуцлагаа мэдэрч, ухамсарласан, нийгмийн хэм хэмжээг сахидаг, бусдад туслалцаа үзүүлэхэд бэлэн, хамтран ажиллах сонирхолтой, 73.3 хувь нь нөхөрсөг, хамтран ажиллах чадвартай, 53.0 хувь нь нээлттэй, илэн далангүй зантай, 48.9 хувь нь аливаа зүйлд сонирхолтой ханддаг, санаачилгатай, өөрчлөлтийг төвөггүй хүлээж авдаг, бүтээлч, уян хатан, 25.2 хувь нь сэтгэл зүйн ачаалал бага, эрч хүчтэй, идэвхтэй зэрэг сайн чанар илэрсэн. Энэ үзүүлэлт нь байгууллагын хувьд хүний нөөц талаас зөв ашиглаж чадвал нөөц боломж болох сайн чанар гэж үздэг байна.

Харин алба хаагчдын 26.4 хувь нь сэтгэл зүйн ачаалал ихэссэн, 29.3 хувь нь невроз буюу архаг ядаргаанд орсон бол 44.9 хувь нь харилцаанд нь түрэмгийлэл илэрч, 30.6 хувь нь идэвх, эрч хүч суларч, ажлын бүтээмжид нөлөөлөх эрсдэл үүсч байна.

➤ Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчийн ажлын хариуцлага, сахилга, харилцааны соёлын түвшинг иргэд хэрхэн үнэлж байгааг тодорхойлох зорилгоор “Эм Эм Си Жи” ХХК-аар судалгаа хийлгэсэн ба судалгааг нийслэлийн 8 дүүргийн хэмжээнд явуулахад оролцогчдын 51.0 хувь нь эмэгтэй, 49.0 хувь нь эрэгтэй ба 51.0 хувь нь 16-34, 46.0 хувь нь 35-54, 3.0 хувь нь 55-64 насны, 69.0 хувь нь цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж байгаагүй, 19.0 хувь нь харилцаж байсан, 9.0 хувь нь гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болж байсан, 3.0 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгуулж байсан иргэд байна.

Судалгаагаар иргэдийн 40.0 хувь нь цагдаа нар иргэдтэй тэгш бус харьцдаг, 34.0 хувь нь танил тал, мөнгө, эрх мэдэлтэй хүнд үйлчилдэг, 37.0 хувь нь хүнд сурталтай, 32.0 хувь нь харилцааны соёлгүй, 44.0 хувь нь дээрэнгүй, бүдүүлэг харьцдаг гэсэн бол иргэдийн цагдаад итгэх итгэл 47.0 хувьтай байна. /Америкийн Нэгдсэн Улсын иргэдийн цагдаад итгэх итгэл 57.0 хувь гэжээ.^{1/}

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаар иргэдийн хандлага ямар байгааг үнэлэх асуулгад 67.0 хувь нь төвийг сахисан буюу дундаж, 24.0 хувь нь эерэг хандлагатай байсныг 2013 онд “IRIM” ХХК-ий хийсэн судалгаатай харьцуулахад төвийг сахисан хандлага 33.0 хувиар өсч, сөрөг хандлага 11.0, эсрэг хандлага 12.0 хувиар тус тус буурсан байна.

Иргэдээр цагдаагийн байгууллагын соёлын түвшинг хөндлөнгөөс үнэлүүлэхэд:

а/ бие даасан байдал, эрх чөлөө 3.6;

б/ эрсдлийг хүлээж авах сонирхол, хандлага 3.5;

в/ нэгдмэл байдал 3.3;

г/ удирдлагын арга барил 3.1;

д/ зөрчилдөөний хэм хэмжээ 3.1;

е/ нийгмийн дэмжлэг, туслалцаа 3.0;

ж/ хяналтын систем 2.9;

з/ харилцааны хэлбэр, загвар 2.9;

и/ шагнал, урамшуулал 2.8, нийт үнэлгээ 3.1 буюу дундаж гэж үнэлсэн байна.

➤ Хууль сахиулахын их сургууль, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэс хамтран 2018 оны нэгдүгээр улиралд “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалтны ур чадвар, сургалтын хэрэгцээ шаардлага” сэдвээр судалгааны ажил хийсэн.

Судалгаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 211 удирдах албан тушаалтан хамрагдсан ба 173 буюу 81.9 хувь нь 35-аас дээш, 38 буюу 18.0 хувь нь 35 хүртэлх насны алба хаагч байна.

Судалгаагаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалтны манлайлал байгууллагын үйл ажиллагааны үр дүн, амжилтад хэрхэн нөлөөлөх, удирдагчийн ур чадварт ямар байр суурь эзэлж болохыг тогтоох зорилгоор санал асуулга явуулахад 17.0 хувь нь удирдагчийн манлайлал, 14.2 хувь нь багийн ажиллагаа, багаар

¹ Эх сурвалж www.gallup.com 2017.06

ажиллах чадвар, 13.7 хувь нь удирдагчийн мэргэжлийн ур чадвар, 12.7 хувь нь хамт олны эв нэгдэл, нэгдмэл зорилго, 12.0 хувь нь багийн гишүүдийн мэдлэг, боловсрол, ур чадвар, 11.2 хувь нь байгууллага дахь харилцаа, соёл гэжээ.

Удирдах албан тушаалтны манлайлах ур чадварын түвшинг үнэлэхэд судалгаанд оролцогчдын 25.5 хувь нь манлайлах чадвар “хангалтгүй” гэж хариулсан нь дөрвөн удирдах албан тушаалтан тутмын нэг нь манлайлах чадвараа дээшлүүлэхэд суралцах шаардлагатай гэж дүгнэжээ.

➤ Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2017 оны байдлаар сахилгын 1268 зөрчилд 1277 алба хаагч холбогджээ. Үүний 63.0 хувийг офицер, 37.0 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна. Сахилгын зөрчлийг урьд оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн тоо 297 буюу 19.0, холбогдсон алба хаагчийн тоо 312 буюу 19.6 хувиар тус тус буурсан сайшаалтай үзүүлэлт гарч байгаа боловч ажлын хариуцлага алдах, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчих, архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчилд холбогдох асуудал буурахгүй байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн хөдөлгөөний байдлыг авч үзвэл, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад нийт 561 иргэн шинээр томилогдож, 348 алба хаагч албанаас чөлөөлөгдөж, 54 алба хаагч өөр байгууллагад шилжиж, 385 алба хаагч цэргийн байнгын тэтгэвэрт гарсан. Нийт бие бүрэлдэхүүний дундаж наслалт 34 байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хэрэглэгчийн үнэлгээний сүүлийн 3 жилийн тайлангаас харахад нийт 5 оноо авахаас 2015 онд 3.6, 2016 онд 3.0, 2017 онд 3.2 оноотой дүгнэгджээ.

Тухайлбал, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хэрэглэгчийн үнэлгээ 2017” иргэдийн сэтгэл ханамжийн судалгаагаар иргэдээс өөрийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сайжруулах, тэднийг иргэдэд ойртуулах чиглэлээр ямар ажил хийх шаардлагатай талаар 810 иргэнээс санал авахад 33.2 хувь нь цагдаагийн алба хаагчид шударга, шуурхай байх, 18.7 хувь нь ёс зүйтэй байх, цагдаагийн алба хаагчдын харилцааны соёлыг дээшлүүлэх, 12.2 хувь нь цагдаагийн алба хаагчдын хүнд суртлыг арилгах, 3.6 хувь нь цагдаагийн алба хаагчдын хууль, дүрэм, журмын мэдлэгийг нэмэгдүүлэх, 3.3 хувь нь цагдаагийн алба хаагчдын хувцас, хэрэгслийг сайжруулах санал гаргасан талаар тайланд дурьджээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас цагдаагийн байгууллага, алба хаагч бүр өргөсөн тангарагтаа үнэнч, улс төр, бизнес, эрүүгийн бүлэглэлээс ангид байж, гагцхүү хуулийн хүрээнд шударгаар ажиллах талаар ч тодорхой үүрэг, чиглэл өгөхийн зэрэгцээ төрийн байгууллагын алба хаагчдын сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах талаар Засгийн газраас 2017 оны 01 тоот албан даалгавар гаргасан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдах ажилтны удирдах арга барилыг сайжруулж, менежментийн оновчтой аргуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, алба хаагчдын хариуцлага, сахилга ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлж, хөдөлмөрийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сэтгэл зүйн болон ажлын ачааллыг бууруулж, “гэр бүл-ажил” гэсэн харьцааг тэнцвэртэй байлгах талаар судлаач, мэргэжилтнүүд зөвлөдөг.

Дээрх нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага нь байгууллагын дотоод, гадаад соёлыг төлөвшүүлэхэд баримтлах бодлогын баримт бичиг буюу “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

“байгууллагын соёл” гэж цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын бие бүрэлдэхүүн нийтээр хүлээн зөвшөөрч, дагаж байгаа дотоод, гадаад орчинтой харьцах харилцааг зохицуулагч үзэл хандлага, сэтгэл зүйн зан харьцаа, туршлага, үйл ажиллагаа,

итгэл үнэмшил, үнэт зүйлсийн цогц буюу байгууллагын онцлог дүр төрхийг харуулж чадахуйц бусдаас ялгарах шинж, гишүүдийн үзэл бодлыг нэгтгэж байгаа хүчин зүйлийг.

“баг” гэж хамтын хэрэгцээ, сонирхол, эрмэлзэл, зорилго, үнэт зүйл, үйл ажиллагааны арга барилын талаар нэгдмэл нэг ойлголт, нэг итгэл үнэмшилтэй хамтын бүтээл, амжилтын төлөө бие биенээ дэмжин ажиллаж буй хүмүүсийн ажил хэрэгч, нөхөрсөг нэгдэл /хэлтэс, тасаг, хэсэг, ажлын хэсэг, хамтрагч гэх мэт/-ийг.

“зөрчил, зөрчилдөөн” гэж бие хүмүүсийн ухамсар дахь эсрэг хандлагын чиглэл, бие хүмүүсийн болон бүлэг хоорондын харьцаанд гарч байгаа тохиролцохгүй хурц, сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилго: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод, гадаад соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааны арга зүйн чиглэл болж, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын хариуцлага, харилцаа, хандлага, сэтгэл ханамжийг дээшлүүлж, иргэдийн цагдаад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилт:

Зорилт 1. Алба хаагчийн хувийн болон харилцааны соёлыг дээшлүүлэн, эерэг хандлага төлөвшүүлж, ажлын хариуцлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 2. Хамт олны нэгдмэл байдлыг ханган, багаар ажиллах чадварыг сайжруулж, байгууллага, нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

Зорилт 3. Удирдлагын манлайлал, үр нөлөөг дээшлүүлж, зөрчилдөөнийг бууруулан, байгууллагын үйл ажиллагааг төгөлдөржүүлнэ.

Зорилт 4. Байгууллагын соёлыг сурталчилж, иргэд, олон нийтийн дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

3.3. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Нэгдүгээр зорилтын хүрээнд

1. Алба хаагчдын харилцааны болон биеэ авч явах соёлыг төлөвшүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, алба хаагч бүрт зөв дадал хэвшүүлэх.

2. Байгууллагын тогтоосон хэм хэмжээ, дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулж, ажил үүргийн соёлыг төлөвшүүлэх.

3. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад анх болон шилжин томилогдсон алба хаагчдыг богино хугацаанд дасан зохицуулах, эерэг хандлагыг төлөвшүүлж, албандаа итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Алба хаагчийн хувийн болон харилцааны соёл, биеэ авч явах байдал сайжирч, эерэг хандлага төлөвшиж, албандаа хандах итгэл үнэмшил, сэтгэл ханамж нэмэгдэнэ.

Хоёрдугаар зорилтын хүрээнд

1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын түүхэн уламжлал, туршлагаасаа байнга суралцаж, байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.

2. Хамт олны шинэлэг санаа, бүтээлч ажиллагааг дэмжиж нэвтрүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

3. Ажлын зохион байгуулалтыг оновчтой болгож, үүргээ ухамсарласан, алба хаагч бүрийн тэгш оролцоог хангасан, нэгдмэл хамт олныг бүрдүүлэх.

Хүрэх үр дүн: Хамтын нэгдмэл зорилго тэмүүлэлтэй, амжилтын төлөө бие биенээ дэмжсэн, ажил хэрэгч, нөхөрсөг, нэгдмэл санаа зорилготой, эрсдлийг даван туулах, өрсөлдөх чадвартай тэргүүлэгч байгууллага, хамт олон болж хөгжинө.

Гуравдугаар зорилтын хүрээнд

1. Удирдах ажилтны манлайлал, удирдлагын сэтгэл зүй, арга барилыг сайжруулж, эрх мэдлийн соёлыг төлөвшүүлэх.

2. Ажлын байран дахь зөрчил, зөрчилдөөнийг бууруулах, шийдвэрлэх, алба хаагчдыг урамшуулах, идэвхжүүлэх оновчтой арга барилыг нэвтрүүлэх.

3. Эрүүл ахуй, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын стандарт шаардлага хангасан, алба хаагчдын ажил үүргээ хэвийн гүйцэтгэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх.

Хүрэх үр дүн: Бүх шатны удирдах ажилтнууд удирдахуйн ухааны арга барилыг эзэмшсэн, эрх мэдлийн соёлыг нэвтрүүлсэн, алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх сэтгэл ханамжийг бүрдүүлсэн, таатай орчин нөхцөл бүрдсэн байна.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд

1. Мэдээлэл түгээх арга зам, давтамж, зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах.

2. Алба хаагчдад хүргэх мэдээ, мэдээллийг оновчтой, хүртээмжтэй, чанартай зохион байгуулж, хэвших.

3. Байгууллагын соёлыг сурталчлахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг, туслалцааг авах, хамтран ажиллах арга хэлбэрийг боловсронгуй болгох.

Хүрэх үр дүн: Алба хаагч, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээ, мэдээллийг хүртээмжтэй, шуурхай, бодитой хүргэж, сурталчлах, тэдний дэмжлэг туслалцааг авах олон талт хамтын ажиллагаа сайжирсан байна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Хүний эрх эрх чөлөөг хүндэтгэж, нууцыг чанд хадгалах.

2. Хууль дээдлэх.

3. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үзэл баримтлалд тулгуурлах.

4. Тэгш хүртээмжтэй, шударга, ил тод, нээлттэй байх.

5. Суралцагч, шинийг санаачлагч, бүтээгч байх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1. Цагдаагийн төв байгууллага

а/ Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

б/ Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх бүх талын арга хэмжээ авна.

в/ Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд үндэслэн нэмэлт тодотгол хийх, боловсронгуй болгох арга хэмжээг авна.

5.2. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

а/ Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх, төлөвшүүлэх, хэвшил, дадал эзэмшүүлэх чиглэлээр харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээг авна.

б/ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, манлайлах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, шаардлагатай бол бүлэг, баг, клуб байгуулан ажиллуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

в/ Хөтөлбөрийн хүрээнд төсөл, дэд хөтөлбөр, удирдамж, төлөвлөгөөний дагуу соён гэгээрүүлэх /сургалт, зөвлөгөөн, аян, тэмцээн, уралдаан гэх мэт/, сурталчлах ажлыг шинэлэг арга, хэлбэрээр тогтмол зохион байгуулна.

г/ Алба хаагчдын гадаад үзэмж, харилцааны соёл, биеэ авч явах байдлыг сайжруулахад дотоодын хяналт шалгалтын үүрэг, оролцоог сайжруулна.

д/ Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх бүх талын арга хэмжээ авна.

5.3. Алба хаагч, албан тушаалтан

а/ Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр идэвх, санаачлагатай ажиллана.

б/ Аливаад хандах хандлага, ажлын хариуцлага, хувийн соёл, сахилга ёс зүйг дээшлүүлэхэд өөрийгөө тогтмол хөгжүүлнэ.

в/ Бусдад урам өгөх, зөв дадал эзэмшүүлэх, эерэгээр нөлөөлөх, үлгэрлэн манлайлах, зарчимч шаардлага тавих зэргээр хамт олноо дэмжиж ажиллана.

г/ Захирах, захирагдах ёсыг эрхэмлэж, удирдах албан тушаалтны хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжих хугацаа, санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлж, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсөв;
- Гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөр, тусламж;
- Бусад эх үүсвэр.

Долоо. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гадаад, дотоод соёл төлөвшин, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын хариуцлага, харилцаа, хандлага, сэтгэл ханамж дээшилж, иргэдийн цагдаад итгэх итгэл нэмэгдэнэ.

7.2. Шалгуур үзүүлэлт

7.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлын үнэлгээ, Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёлын үнэлгээ, Хэрэглэгчийн үнэлгээг тус тус суурь үзүүлэлт болгоно.

| Хөтөлбөрийн зорилго, зорилт | Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт 2018 он | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин |
|---|---|------------------------|---------------|---------------|
| Зорилт 1. Алба хаагчийн хувийн болон харилцааны соёлыг дээшлүүлэн, эерэг хандлага төлөвшүүлж, ажлын хариуцлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ. | Алба хаагчдын харилцааны болон биеэ авч явах соёлыг төлөвшүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, алба хаагч бүрт зөв дадал хэвшүүлсэн байх. | 58.6 /2.9/ | 64.0 /3.2/ | |
| | Байгууллагын тогтоосон хэм хэмжээ, дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулж, ажил үүргийн соёлыг төлөвшүүлсэн байх. | 76.0 /3.8/ | 80.0 /4.0/ | |
| | Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад анх болон шилжин томилогдсон алба хаагчдыг богино хугацаанд дасан зохицуулах, эерэг хандлагыг төлөвшүүлж, албандаа итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлсэн байх. | 76.0 /3.8./ | 80.0 /4.0/ | |

| | | | | |
|--|--|---------------|---------------|--|
| Зорилт 2.Хамт олны нэгдмэл байдлыг ханган, багаар ажиллах чадварыг сайжруулж, байгууллага, нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ. | Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын түүхэн уламжлал, туршлагаасаа байнга суралцаж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн байх. | 76.0 /3.8/ | 80.0 /4.0/ | |
| | Хамт олны шинэлэг санаа, бүтээлч ажиллагааг дэмжиж нэвтрүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байх. | 76.0 /3.8/ | 80.0 /4.0/ | |
| | Ажлын зохион байгуулалтыг оновчтой болгож, үүргээ ухамсарласан, алба хаагч бүрийн тэгш оролцоог хангасан байх. | 76.0 /3.8/ | 80.0 /4.0/ | |
| Зорилт 3.Удирдлагын манлайлал, үр нөлөөг дээшлүүлж, зөрчилдөөнийг бууруулан, байгууллагын үйл ажиллагааг төгөлдөржүүлнэ. | Удирдах ажилтны манлайлал, удирдлагын сэтгэл зүй, арга барилыг сайжруулж, эрх мэдлийн соёлыг төлөвшүүлсэн байх. | 62.2 /3.1/ | 70.0 /3.5/ | |
| | Ажлын байран дахь зөрчил, зөрчилдөөнийг бууруулах, шийдвэрлэх, алба хаагчдыг урамшуулах, идэвхжүүлэх оновчтой арга барилыг нэвтрүүлсэн байх. | 62.2 /3.1/ | 70.0 /3.5/ | |
| | Эрүүл ахуй, аюулгүй байдал, хөдөлмөр хамгааллын стандарт шаардлага хангасан орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх. | 62.2 /3.1/ | 70.0 /3.5/ | |
| Зорилт 4. Байгууллагын соёлыг сурталчилж, иргэд, олон нийтийн дэмжлэг туслалцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. | Мэдээлэл түгээх арга зам, давтамж, зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангасан байх. | 58.6 /2.9/ | 64.0 /3.2/ | |
| | Алба хаагчдад хүргэх мэдээ, мэдээллийг оновчтой, хүртээмжтэй зохион байгуулсан байх. | 76.0 /3.8/ | 80.0 /4.0/ | |
| | Байгууллагын соёлыг сурталчлахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг, туслалцааг авсан байх. | 60.0 /3.0/ | 70.0 /3.5/ | |
| | Хамтран ажиллах арга хэлбэрийг боловсронгуй болгосон байх. | 76.0 /3.8/ | 80.0 /4.0/ | |

Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалт болон Аюулгүй байдал хариуцсан нэгж хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит, хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ, шинжилгээ хийлгэж болно.

8.3. Анги, байгууллагад явуулах төлөвлөгөөт болон хэсэгчилсэн шалгалтаар хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнд оруулан тооцно.

8.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 7.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Ес. Хэрэгжилтийг тайлагнах, үр дүнг тооцох


9.1. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага нь хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг жил бүрийн 06, 12 дугаар сарын 10-ны дотор гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

9.2. Хүний нөөц, сургалт хариуцсан нэгж нь биелэлтийг нэгтгэн дүгнэж, дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулж, шийдвэр гаргуулна.

9.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг анги, байгууллагын дарга /захирагч/-ын зөвлөлийн хуралдаанаар улирал бүр хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга замыг тодорхойлно.

9.4. Хөтөлбөр, төлөвлөгөөний зорилго, зорилтыг ханган биелүүлэхэд идэвх, зүтгэл, үр бүтээл гарган ажилласан байгууллага, хамт олон, албан тушаалтныг шагнаж урамшуулан, хэрэгжилт хангалтгүй анги, байгууллагын холбогдох албан тушаалтанд хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



БАТЛАВ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

С.БААТАРЖАВ

2018 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

“БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ДЭЭШЛҮҮЛЬЕ” АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго, хамрах хүрээ, хугацаа

1.1. Зорилго: “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангаж, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын хариуцлага, харилцаа, хандлага, сэтгэл ханамжийг дээшлүүлж, иргэдийн цагдаад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд оршино.

1.2. Хамрах хүрээ: Цагдаа, дотоод цэргийн анги, байгууллага.

1.3. Хугацаа: 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр.

1.4. Аяныг зохион байгуулах нэгж: Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэс, Хүний нөөц, сургалтын хэлтэс.

Хоёр. Аяны хүрээнд хийгдэх ажил

2.1. “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийг бие бүрэлдэхүүнд сурталчлан таниулах.

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажил, арга хэмжээг бодитой, үр дүнтэй зохион байгуулах. Үүнд:

-Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, бусад холбогдох эрх зүйн актуудыг сурталчлах, сургалт явуулах, мөрдүүлж, хэрэгжилтийг сайжруулах.

-алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны болон хувийн соёлыг дээшлүүлэх, алба хаагч бүрт зөв дадал эзэмшүүлж, төлөвшүүлэх.

-удирдах ажилтны манлайлал, удирдлагын сэтгэл зүй, арга барилыг сайжруулж, удирдахуйн ухааны оновчтой аргуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

-анх болон шилжин томилогдсон алба хаагчдыг богино хугацаанд дасан зохицуулах, эерэг хандлага төлөвшүүлэх.

-алба хаагчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх, орчин, нөхцөлийг сайжруулах.

-алба хаагчдын шинэлэг бүтээлч, санал, санаачилгыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх.

-байгууллагын үйл ажиллагаа сурталчлах, иргэд, олон нийтийн дэмжлэг, туслалцааг авч, хамтран ажиллах.

2.3. Арга хэмжээг хэрэгжүүлэхдээ алба хаагчдаас аливаа хэлбэрээр мөнгө татах, албадан хөдөлмөрлүүлэх, хандив тусламж гуйх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглох ба хуулийн хүрээнд байгууллага, нэгжийн гишүүд сайн дурын үндсэн дээр хамтын хөдөлмөрөөрөө хөрөнгө босгох, орон нутаг, иргэд, олон нийтээс дэмжлэг авч болно.

Гурав. Дүгнэх

3.1. Аяныг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ирүүлсэн тайлан, хийсэн ажлын үр дүнг харгалзан дүгнэнэ. Шаардлагатай бол ажлын хэсэг тухайн байгууллага дээр очиж, аяны хүрээнд хийсэн ажил, арга хэмжээтэй танилцана.

3.2. Хамрагдах байгууллага, нэгжийг үйл ажиллагаа, чиг үүргийн онцлог, бүтэц, зохион байгуулалтыг харгалзан дараах байдлаар бүлэглэнэ.

-Цагдаагийн ерөнхий газрын харъяа нэгж.

-Албад, Нийслэлийн цагдаагийн газар, Дотоодын цэргийн штаб.

-Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага /аймаг, дүүрэг, Төмөр зам, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн газар, хэлтэс/.

3.3. Анги, байгууллага нь аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний явц байдлын талаар тайлан, танилцуулгыг төлөвлөгөөний заалт бүрээр гаргаж, бичмэл хэлбэрээр, тодорхой баримт, гэрэл зургийн хамт 2018 оны 08 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 15-ны дотор Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст ирүүлнэ. Хугацаа хоцорч ирүүлсэн тайланг дүгнэхгүй.

3.4. Ажлын хэсэг нь аяныг 2018 оны 12 дугаар сарын 10-ны дотор багтаан дүгнэж, дүгнэлт, саналаа Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчид танилцуулна.

Онцгой үр нөлөөтэй арга хэмжээ, удирдлагын арга барил нэвтрүүлж, хэрэгжүүлсэн албан тушаалтан, байгууллагын ерөнхий үнэлгээнд 20% хүртэлх үнэлгээ нэмж болно.

Дөрөв. Шагнал урамшуулал

4.1. Удирдамжийн 3.2 дахь хэсэгт заасан бүлэг тус бүрээс 1, нийт 3 байгууллага, нэгжийг шалгаруулж тус бүр өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж, урамшуулна.

4.2. Аянд хангалтгүй оролцсон анги, байгууллагын дарга, захирагчид шийтгэл оногдуулна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

